

БАТЛАВ
ДОРНОГОВЬ АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Г.БАТЛХАМ



БАТЛАВ
САЙНШАНД САЛХИН ПАРК ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Э.МЯГМАРДОРЖ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
СПОРТ ЗААЛЫГ АШИГЛАХ ГЭРЭЭ

№ 23/с -30

Нэг. Гэрээний зорилго

Аймгийн төвийн албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажилчин албан хаагчдын чөлөөт цагаа зөв боловсн өнгөрүүлэх тэднийг хүмүүжүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, ажиллах чадварыг дээшлүүлэх, бие бялдараа чийрэгжүүлэхэд оршино.

Аймгийн Биеийн тамир, спортын газрыг төлөөлж нягтлан бодогч ажилтай Д.Болормаа, Сайншанд Салхин Парк ХХК-ийг төлөөлж Дотоод хяналтын мэргэжилтэн Б.Цэндсүрэн нар харилцан тохиролцож, энэхүү гэрээг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 9 сарын хугацаатай байгуулав.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Сайншанд Салхин Парк ХХК-ийн албан хаагчид нь БТСГазрын Спорт цогцолборын заалыг долоо хоногийн Пүрэв гарагийн 20.00-22.00 цагийн хооронд Биеийн тамир, спортын арга хэмжээнд зориулан ашиглана.

2.2. Тухайн байгууллагын хуваарьт цагаар улс, бүс, аймгийн чанартай арга хэмжээтэй болбол хоёр тал хэлэлцэн тохирч БТСГазрын мэдэлд ашиглана.

2.3. Заалны төлбөр 400,000 (Дөрвөн зуун мянга) төгрөгийг сар бүрийн 25-ны дотор Төрийн сан дахь БТСГазрын 100060008009 харьцах дансанд тушаасан байна.

2.4. Заал ашиглалтын үед эд хогшил, ариун цэвэр бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцаж хохирол гаргасан тохиолдолд хохирлыг барагдуулна.

2.5. Хоёр тал харилцан тохирч гэрээнээс өмнө цуцалж болно.

2.6. Хүндэтгэх шалтгаангүйгээр заал ашигласны нэг сарын төлбөрийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд төлбөрийг бүрэн барагдуулж, БТСГазрын санаачилгаар гэрээг цуцална.

Гурав. Аймгийн Биеийн тамир, спортын газрын хүлээх эрх, үүрэг

3.1. Заалыг ашиглах хугацаанд нь талбайн цэвэрлэгээ, гэрэлтүүлэг шаардлагатай хэрэглэлээр хангана.

3.2. Заал ашиглалтын үед үйл ажиллагаанд саад болох өөр үйл ажиллагаа зэрэгцүүлэн явуулахгүй байна.

3.3. Заал ашиглалтыг 20.00 цагт эхэлж 22.00 цагт дуусгах шаардлага хяналтыг тавина.

3.4. Зөвхөн байгууллагын ажилчин, албан хаагчид орохыг шаардах бөгөөд заавал тухайн байгууллагын зохион байгуулагчтай байхыг шаардана.

3.5. Гэрээ ёсоор 20.00 цагт ашиглалт эхлэх бөгөөд 22.00 цагаас хойш хоцорсон хугацааг сунгаж үйлчлэхгүй.

Дөрөв. Сайншанд Салхин Парк ХХК-ийн хүлээх эрх, үүрэг

4.1. Биеийн тамир, спортын арга хэмжээг хуваарийн дагуу Пүрэв гараг бүрийн **20.00-22.00** цагт багтаан заалны ариун цэвэр, дэг журмыг сахиж **биеийн тамирын хувцас, пүүз, кетийг** сольж үйлчлүүлнэ.

4.2. Зааланд гадны хувцас, гадуур өмссөн пүүз кеттэй орохыг **хатуу** хориглоно.

4.3. **Согтууруулах ундаа хэрэглэсэн буюу хэвийн бус байхыг хориглоно.** Заланд зориулалтын бус газар хаяхгүй байх.

4.4. Заалны цэвэрлэгээ, үйлчилгээний талаар санал, гомдлыг байгууллагын захиргаанд тавина.

4.5. **Тухайн хуваарьт цагтаа танай байгууллагаас шалтгаалан заалаа ашиглаагүй тохиолдолд нөхөн олгохгүй бөгөөд тоголсонд тооцож төлбөрийг бүрэн багагдуулна. Анхаарна уу.**

4.6. Байгууллагын биш хүмүүсийг оруулахыг хориглох бөгөөд бага насны хүүхдүүдийнхээ аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

Гэрээг байгуулсан:

Аймгийн БТСГазрыг төлөөлж:
Нягтлан бодогч
Д.Болормаа
Утас: 99203764, 90113764
2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр

Сайншанд Салхин Парк ХХК-ийг төлөөлж:
Дотоод хяналтын мэргэжилтэн
Б.Цэндсүрэн
Утас: 75050055, 90808909
2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр

Салхин / *М. Эрдэнэтос*
эрхтэт захиал.

БАТЛАВ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА *Автанг* Г.БАТЛХАМ

БИЕИЙН ТАМИРЫН ЗААЛАНД МӨРДӨХ ЖУРАМ 025723

- Согтууруулах ундаа хэрэглэсэн хүнд үйлчлэхгүй бөгөөд зааланд хэрэглэхийг хориглоно.
- Тамхи татах, ус ундааны сав, бохь, хог цаасыг ил задгай хаяхыг хориглоно.
- Зааланд шүлс, цэр хаяхыг хориглоно.
- Сагсан бөмбөг, гар бөмбөгийг заалнаас бусад газар ашиглах, цонх, хана руу шидэх, өшиглөхийг хориглоно.
- Тоглолтын талбайд гадуур хувцас, гуталтай орохыг болон тоглолтын кет, пүүзтэй заалнаас гарахыг хориглоно.
- Хувцас солих өрөөнд хувцсаа солиогүй секц, дугуйлангийн тамирчид болон гэрээт байгууллагын албан хаагчдад заалаар үйлчлэхгүй.
- Секц, дугуйлангийн хүүхдүүд спортоор хичээллэх зөвшөөрлийн үнэмлэхээ авчраагүй тохиолдолд заалаар үйлчлэхгүй.
- Гэрээт байгууллагыг гэрээнд заасан өдөр болон цагийн хуваарийн дагуу оруулж, хуваарийн дагуу ороогүй гэрээт аж ахуй нэгж, байгууллагыг нөхөж сунгахгүй.
 - Гэрээт байгууллагуудын ажилтан, албан хаагч нар зааланд тоглохдоо тухайн байгууллагын албан хаагчдаас бусад хүмүүсийг оруулж, нэвтрүүлэхийг хориглоно.
 - Заалны доторх эд хогшлыг өшиглөх, гэмтээхийг хориглоно.
 - Спортын хэрэгслийг авч явах, үрэгдүүлэх, дутаах зэрэг хохирол гаргасан бол 3 дахин нугалж төлүүлнэ.

Жич: Дээрх зөрчлийг гаргасан гэрээт байгууллага болон аж ахуй нэгж, иргэд хохирлыг бүрэн барагдуулах бөгөөд гэрээт байгууллагатай хийсэн гэрээг цуцлах, аж ахуй нэгж, иргэдэд үйлчлэхгүй болно.